



ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2024 оны 7 дугаар сарын 9

Зээлийн дугаар ба нэр: **ЗЭЭЛ 3694-MON(OCR): Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төсөл**

Гэрээний дугаар ба нэр: **BYW.CW9: Баянхошуу дэд төвийн Б-15, Б-13 талбарын “Ус дулаан дамжуулах төв-6”-ийн доторх тоног төхөөрөмжийн өргөтгөлийн ажил**

Үнийн санал хүлээн авах эцсийн огноо ба цаг: **2024 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 15:00 цаг**

1. Монгол Улс Азийн хөгжлийн банк (цаашид “АХБ” гэх)-наас **Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл салбарын төслийг** хэрэгжүүлэх зорилгоор зээл авсан ба энэхүү санхүүжилтийн тодорхой хэсгийг дээр дурьдсан гэрээний хүрээнд хийгдэх төлбөрт ашиглана.
2. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (цаашид “захиалагч” гэх) нь **Баянхошуу дэд төвийн Б-15, Б-13 талбарын “Ус дулаан дамжуулах төв-6”-ийн доторх тоног төхөөрөмжийн өргөтгөлийн ажил** - д үнийн санал ирүүлэхийг урьж байна.
3. Сонгон шалгаруулалтыг АХБ-ны харьцуулалтын аргаар зохион байгуулна.
4. Зөвхөн доор дурдсан шалгуур үзүүлэлтийг хангасан эрх бүхий оролцогч үнийн санал ирүүлнэ:
 - Барилга угсралтын ажлын тусгай зөвшөөрлүүдтэй байх. Үүнд: БХБЯ-ны БА-6.2 “Барилга байгууламжийн дотор халаалт, салхивчийн шугам сүлжээ, Хөргөх байгууламж тэдгээрийн тоног төхөөрөмж, гадна салбар шугам сүлжээний угсралт” БА-3.4 “Дулааны гол (магистраль) шугам сүлжээ, түүний тоног төхөөрөмжийн угсралт” эсхүл ЭХЯ-ны ТЗ-5.1 0.7-16.0 кгх/см² даралттай зууны угсралт, засварын ажил, түүний туршилт тохируулгын ажил үйлчилгээ,
 - Сүүлийн 5 жилд (2019, 2020, 2021, 2022, 2023) агуулга ба иж бүрдлийн хувьд санал авах хүсэлтэнд дурдсан ажилтай дүйцэхүйц, нэгээс доошгүй ажлыг хийсэн үндсэн гүйцэтгэгчийн туршлагатай байх, ингэхдээ 110.0 сая төгрөгөөс доошгүй байх; Тухайн ажлыг гүйцэтгэж дуусгасан талаар захиалагчийн тодорхойлолттой байх;
 - Энэ ажлыг амжилттай хэрэгжүүлж дуусгахад шаардагдах санхүүгийн нөөц хөрөнгө нь 145.0 сая төгрөгөөс доошгүй байх;
 - Сүүлийн 5 жилийн (2019, 2020, 2021, 2022, 2023) борлуулалтын доод хэмжээ нь эдгээр жилүүдээс дурын 3 жилийн дунджаар тооцсоноор 220.0 сая төгрөг байх.
5. Угсралтын ажлыг 2024 оны 8 дугаар сарын 25-ний дотор гүйцэтгэж туршилт тохируулгыг хийн, захиалагч эзэмшигч байгууллагын хүлээн авах комист хүлээлгэн өгнө.
6. Сонирхсон оролцогч Үнийн санал ирүүлэх ажлын техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг дараах хаягаар авч болно.

Захиалагч

: Нийслэлийн засаг даргын тамгын газар

Харилцах ажилтан : **ТХН-ийн худалдан авах ажиллагааны
мэргэжилтэн**
Гудамж : **Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Чингисийн
Өргөн чөлөө -8, Экспресс тауэр**
Давхар/өрөөний дугаар : **14 давхар, 10 тоот**
Хот : **Улаанбаатар хот**
Улс : **Монгол улс**
Утас : **+976 77770024, +976 77770023**
Факс : **+976 77770024**
Цахим шуудангийн хаяг : **procurement@mub-ahurp.mn**

6. Үнийн саналыг дээрх хаягт 2024 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 15.00 цагаас өмнө ирүүлнэ. Саналуудыг, оролцохоор шийдвэрлэсэн гүйцэтгэгчдийн төлөөлөгчийг байлцуулан, 2024 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 15.00 цагт дээрх хаяг бүхий газарт нийтийн өмнө нээнэ.